

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Чингэлтэй дүүргийн Худалдан авах ажиллагааны алба нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “Сантехникийн засвар үйлчилгээ /3 дугаар хороо, 50.0-ийн 15 дугаар байр/”-ний ажлыг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Тендер шалгаруулалтын дугаар: **ЧДХААА ОНХС А20/05**

Үнийн санал ирүүлэх ажлын зураг, төсөв, тоо хэмжээ болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2020 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 10 цаг 00 минут**-аас өмнө Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 10 цаг 20 минут**-д нээнэ.

Тендерийн материалыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) хаягаар өөрийн аж ахуйн нэгжийн тоон гарын үсгийг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (pdf)-ээр илгээнэ.

Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж **50.000** /тавин мянга/ төгрөгийг www.tender.gov.mn-ээр банкны цахим төлбөр тооцооны системийг ашиглан төлнө.

Дотоодын давуу эрх тооцох эсэх: **Тооцно.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Ж. Самбуугийн гудамж-16,
Нийслэлийн Засаг захиргааны байгууллагуудын II байр, Чингэлтэй дүүргийн Засаг даргын
тамгын газрын байр, Худалдан авах ажиллагааны алба, 5 дугаар давхар 511 тоот
Утас: 70110769

Цахим хаяг: www.tender.gov.mn, www.chingeltei.gov.mn